



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 21/680/ТЗ тоот албан бичгийн дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151030052

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 40 дугаар сарын 06 ны өдрийн
416 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Алтай эколог" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 3.4, 6.1, 6.2, 6.3, 7.1	5
2	"Ханзол" ХХК	Зураг төсөл, шинэ ЗТ-2.1, 8.1, 10.2	5

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 40 дугаар сарын 16-ны өдрийн
416 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Ди Юу Би Би" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-6.3, 6.4	5
2	"Манхан-Уст" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-4.1, 6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1	5
3	"Хүчхүр сод" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-6.1, 6.2	5
4	"Хайтауэр" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-3.1	5